

<p>Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл</p>	<p>..... /шаардлагатай мэдээллийг тусгах/</p>
<p>Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал</p>	<ul style="list-style-type: none"> • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар; • Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний хуулбар); • Санхүүгийн чадварыг нотлох баримт (иргэн бол харилцагч банкны тодорхойлолт /зээл/, сүүлийн 1 жилийн дансны хуулга, хуулийн этгээд бол сүүлийн 2 жилийн аудитлагдсан тайлан, татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт) ; • Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийг нотариатаар баталгаажуулсан хуулбар; • Шаардлагатай тохиолдолд худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлийн технологийн баримт бичиг; • Талбай болон үндсэн хөрөнгө түрээслэх үнийн санал. <p>..... /Түрээслүүлэх эд хөрөнгийн нөхцөл байдал, онцлогоос хамааран түрээслүүлэгч нь нэмэлт материал шаардаж болох бөгөөд зард заавал тусгах/</p>

Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч байгууллага дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг утсаар болон цахим хуудаснаас авна уу.

Хаяг:

Холбогдох албан тушаалтан:

Утасны дугаар:

2. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, нээх, дүгнэх аргачлал

2.1. Сонгон шалгаруулалтын материал ирүүлэх:

2.1.1. Оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд, бүрэн бүрдүүлж битүүмжлэн ирүүлнэ. Бүрдүүлсэн материалын жагсаалтыг дугтуйны гадна талд бичсэн байна.

- 2.1.2. Оролцогч нь зард заасан хугацаанд материалаа өөрийн биеэр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгнө.
- 2.1.3. Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно.
- 2.1.4. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг сонгон шалгаруулалт зохион байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор тухайн байгууллагад гаргана.
- 2.1.5. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

2.2. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, нээх:

- 2.2.1. Түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтан сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд ирүүлсэн материалыг бүртгэж, хүлээн авна. Бичиг хэргийн ажилтан битүүмжлээгүй, хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
- 2.2.2. Бичиг хэргийн ажилтан сонгон шалгаруулалтын материалыг бүртгэлийн хамт ажлын хэсгийн нарийн бичигт тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгнө.
- 2.2.3. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын материалыг нээж, бүрдлийг шалган Нээлтийн тэмдэглэл үйлдэнэ
- 2.2.4. Сонгон шалгаруулалтын материалын бүрдэл дутуу тохиолдолд оролцогчийг үл маргах журмаар хасна.

2.3. Сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх:

- 2.3.1. Ажлын хэсэг хуралдах бүр тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтөлж зохих ёсоор баталгаажуулна.
- 2.3.2. Ажлын хэсгийн гишүүн бүр сонгон шалгаруулалтын материалтай бүрэн танилцсаны үндсэн дээр энэхүү зааврын дагуу дүгнэнэ.
- 2.3.3. Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан, ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээний нийлбэрээр оролцогчийг шалгаруулж, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчээр сонгон шалгаруулна.
- 2.3.4. Ажлын хэсгийн нарийн бичиг хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, гишүүдийн онооны хуудсыг нэгтгэх, оролцогчдын материалыг хадгалах, зохих заавар журмын дагуу архивд шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 2.3.5. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг материал нээснээс хойш ажлын 10 (арван) өдрийн дотор энэхүү зааварт заасны дагуу дүгнэсэн байна.
- 2.3.6. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг шалгарсан оролцогчид мэдэгдэл, бусад оролцогчид үндэслэл бүхий хариу хүргүүлнэ.
- 2.3.7. Мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 (таван) өдрийн дараа сонгон шалгаруулалтын тайлан (оролцогчдын материал, гишүүдийн үнэлгээний хуудас, хурлын тэмдэглэл, мэдэгдэл, үндэслэл бүхий хариу бичиг)-г иж бүрдэл болгон бэлтгэнэ
- 2.3.8. Ажлын хэсэг нь түрээсийн гэрээг байгуулах гэрээний төслийг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

3. Сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх үнэлгээний хуудас

.. оны ... сарын өдөр

Улаанбаатар хот

Д/д	Сонгон шалгаруулал- тад оролцогчийн нэр	Үнэлгээ /Шалгуур үзүүлэлтээр нийт 100 оноо/					Нийт оноо /100 оноон оос/
		Материалын бүрдэл /15 оноо/	Туршлага /15 оноо/	Ажиллах хүчний чадвар /20 оноо/	Санхүүгийн чадвар /25 оноо/	Төрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх үнийн санал /25 оноо/	
1							
2							

Жич:

- Оролцогчийн эрхлэх үйл ажиллагаа нь түрээслүүлэх эд хөрөнгийн зориулалтад нийцсэн байх;
- Түрээслэгчийн сонгон шалгаруулалтад оролцогчдын бүрдүүлбэл зохих материалыг хангасан оролцогчийн материалыг дүгнэнэ.
- Үнийн саналыг хувилж бодох аргачлалаар бодох бөгөөд 1 м.кв байр талбай түрээслэх хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 25 оноо өгнө.

Дүгнэсэн: Ажлын хэсгийн /...../

4. Сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцох

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг дараах нөхцөлд хүчингүйд тооцно.

- 4.1. Түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг холбогдох маягтын дагуу зарлаагүй.
- 4.2. Ажлын хэсэг материал нээснээс хойш ажлын 10 (арван) өдрийн дотор үнэлгээг хийгээгүй.
- 4.3. Ажлын хэсгийн гишүүд нь түрээслэгчийн сонгон шалгаруулалтад оролцож буй иргэн, хуулийн этгээдэд давуу байдал үүсгэсэн нь тодорхой болсон, сонгон шалгаруулалтыг дүгнэх маягтын дагуу үнэлгээг хийгээгүй.
- 4.4. Сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцох эсэх асуудлыг тухайн түрээслүүлэгч байгууллага шийдвэрлэнэ.

----- оОо -----